

**“ЖИДАКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 4-р сарын 19 өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Хурал 2023 оны 4-р сарын 19-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо, орхон-1, Шинэ монгол хаад групп ХХК-ийн байр, 2 давхарын хурлын танхимд хуралдав.

Хурлын дарга Т.Төгс-Од: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 2023 оны “Жидакс” ХК-н Хувьцаа эзэмшигчдийн Ээлжит хурал нээснийг мэдэгдье. Хуралд:

1. Т.Төгс-Од - Хурлын дарга
2. Lee Jeoung Ho - “Эм Ди Кэй Ай” ХХК-г төлөөлж /Хувьцаа эзэмшигч/
3. С.Баясгалан - Тооллогын комиссын дарга
4. Д.Булгамаа - Хурал зохион байгуулах комиссын гишүүн
5. Б.Ариунболд – “Жидакс” ХК-н ТУЗ-н хараат бус гишүүн нар оролцож байна.

Хурлын дэгийн дагуу Тооллогын комисс ирцийн мэдээлэл танилцуулна уу.
Тооллогын комиссын дарга С.Баясгалангийн танилцуулснаар Хурлын ирц:

2023 оны 3-р сарын 10-ны өдрийн “Жидакс” ХК-н 23/01 тоот ТУЗ-н тогтоолд Хувьцаа эзэмшигчдээс хурлын өдөр саналын хуудсаар санал авахаас гадна брокер дилерийн компаниар урьдчилан санал авах сүүлчийн өдрийг 2023 оны 4-р сарын 14-ний өдрөөр тогтоож өгсөн. “Эм Ди Кэй Ай” ХХК-г төлөөлж Хувьцаа эзэмшигч Lee Jeoung Ho Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналаа ирүүлсэн байна. “Жидакс” ХК нийт гаргасан 13,735,752 ширхэг хувьцаатай, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр буюу 2023 оны 3-р сарын 31-ний өдрөөр нийт 166 хувьцаа эзэмшигч байна. Үүнээс 13,587,865 ширхэг хувьцаатай “Эм Ди Кэй Ай” ХХК буюу 99.07 хувийн хувьцаа эзэмшигч хуралд оролцсоноор Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэхь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4 дүгээр заасны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов. Оролцсон хувьцаа эзэмшигч:

№	Хувьцаа эзэмшигчийн овог нэр	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшил хувь
1	“Эм Ди Кэй Ай” ХХК-г төлөөлж Lee Jeoung Ho	13,587,865	99.07%
Нийт		13,587,865	99.07%

Хурлын ирц 100 % болохыг Хурлын даргад мэдээлж байна.

Хурлын дарга: Тооллогын комиссын хурлын ирцийг мэдээг сонслоо. Хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 03-р сарын 10-ны өдрийн 23/01 тоот тогтоол болон хурлын дэгийн дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Хэлэлцэх асуудал, холбогдох материалууд урьдчилан хувьцаа эзэмшигч нарт хүргэгдсэн болно.

Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудалдаа орьё. Үүнд:

Хэлэлцэх асуудал 1: Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг хэлэлцэх тухай.

Т.Төгс-Од: Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны болон санхүү байдлын тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах,

ТУЗ-н хараат бус гишүүн Б.Ариунболд: Асуулт асууя Хурлын даргаа, Хувьцаа эзэмшигч нарт компанийн санхүүгийн тайлан үзэж танилцах боломж байдаг уу?

Хурлын дарга Т.Төгс-Од: Бүх хувьцаа эзэмшигч нарт нээлттэй, монголын хөрөнгийн бирж болон санхүүгийн зохицуулах хороонд бичгээр хүргэгдэн, компанийн албан ёсны мэйл хаягаар ороход нээлттэй компани учраас харж танилцаж болдог байгаа.

ТУЗ-н хараат бус гишүүн Б.Ариунболд: Ойлголоо баярлалаа.

Lee Jeoung Ho: Компани цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлж, ашигтай ажиллана гэдэгт найдаж байна. Иймээс компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг батлах саналтай байна.

Хурлын дарга Т.Төгс-Од: Өөр санал бнуу, байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудал руу орьё.

Шийдвэр 1:

Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан болон санхүү байдлын тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 2: ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай.

Т.Төгс-Од: 2022 оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангаас харахад ТУЗ-н гишүүдэд цалин урамшуулал олгох боломжгүй гэж үзэж байна.

Lee Jeoung Ho: Компанийн үйл ажиллагаа тогтвортой, өргөжин тэлж ашиг олоод эхлэхээр цалин урамшуулал олгоно гэдэгт итгэж байна. Иймд энэхүү саналыг дэмжиж байна.

Хурлын дарга Т.Төгс-Од: Өөр санал бнуу, байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудал руу орьё.

Шийдвэр 2:

Компани 2022 онд ТУЗ-ийн цалин, урамшуулал олгохгүй байхаар БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 3: ТУЗ-ийн гишүүдийг танилцуулах тухай.

Т.Төгс-Од: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд дараах нэр бүхий гишүүдийг нэг жилийн хугацаатайгаар улируулан сонгох,

Хараат бус гишүүд:

- Лхагвасүрэн овогтой Ганчимэг
- Бямбаа овогтой Ариунболд
- Жаргалсайхан овогтой Билэгдэмбэрэл

Ердийн гишүүд:

- Lee овогтой Jeoung Ho
- Төмөрбаатар овогтой Төгс-Од
- Бямбаа овогтой Нарантуяа
- Дашням овогтой Гантуул
- Доржготов овогтой Пүрэвдорж
- Дорлигжав овогтой Болормаа

Т.Төгс-Од: Одоо ажиллаж байгаа нийт гишүүдийг нэг жилийн хугацаатайгаар томилох саналтай байна,

Lee Jeoung Ho: Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг нэг жилийн хугацаатайгаар улируулан сонгохыг зөвшөөрч байна.

Шийдвэр 3:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдээр дараах гишүүдийг улируулан СОНГОСУГАЙ.

Ердийн гишүүд:

- Lee овогтой Jeoung Ho
- Төмөрбаатар овогтой Төгс-Од
- Бямбаа овогтой Нарантуяа
- Дашням овогтой Гантуул
- Доржготов овогтой Пүрэвдорж
- Дорлигжав овогтой Болормаа

Хараат бус гишүүд:

- Лхагвасүрэн овогтой Ганчимэг
- Бямбаа овогтой Ариунболд
- Жаргалсайхан овогтой Билэгдэмбэрэл нарыг сонгосугай.

Хурлын дарга Т.Төгс-Од: Тооллогын комисс санал хураалтаа хураах уу.

Тооллогын комисс: Санал хураалт дууслаа, саналын хуудас хүчинтэй тул тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулья. Хурлын даргад хүчинтэй саналын хуудас, тогтоолыг гардуулж өгье.

Хурлын дарга: Тооллогын комиссын тогтоолыг тусган хурлаас гарах Хувьцаа эзэмшигчдийн Ээлжит хурлын Тогтоолыг уншиж танилцуулья.

Тогтоолоо батлахуу, хуралд оролцсон хувьцаа эзэмшигч зөвшөөрсөнөөр Хурлын тогтоол батлагдлаа.

Хурлын дарга Т.Төгс-Од: Хуралд оролцсон “Жидакс” ХК-н ТУЗ-н хараат бус гишүүн Б.Ариунболд болон хуралд оролцсон бүх хүмүүст баярласан талархалаа илэрхийлж 15:00 цагт хурал өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:

Д.Булгамаа Д.БУЛГАМАА

Танилцсан Хурлын дарга:

Төгс-Од Т.ТӨГС-ОД